НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

2025 оны 05 дугаар сарын 12

Улаанбаатар хот

| Д/д | Зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтийн эх | Суурь түвшин | | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Зорилтот түвшин | Санхүүжилт сая.төгрөг | Төсвийн гүйцэтгэл | Хэрэгжилтийн явц | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | он | түвшин | | | | | | | |
| НЭГ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | | | | | | | |
| 1.3 Дэд бүтэц | | | | | | | | | | | | | |
| 1.3.3 Ариутгах татуурга | | | | | | | | | | | | | |
| 54 | МУХТЖҮЧ-2.5.6, 9.3.3 НХТЖҮЧ-9.17.1, 9.17.2 | "Улаанбаатар хотын үйлдвэрийн хаягдал усны хяналтын чадавх бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд хаягдал устай холбоотой нэгдсэн удирдлага зохицуулалтын менежментийг сайжруулах, хяналт шалгалт, зөвлөх ажлыг бохирдуулагч үйлдвэрийн ангилал бүрээр зохион байгуулж ажиллах | УБЗАА, НХШГ, НБОГ | - | 2023 | 30 | Төслийн хэрэгжилт | хувь | 100 | - | | Төвлөрсөн бохир усны шугамын дамжин хэрэглэгч үйлдвэр, үйлчилгээ, аж ахуйн нэгж байгууллагын бохир усны гаргалгаа шугамд бохирдол бууруулах тоног төхөөрөмж, суурилуулалт үйлдвэрүүдийн урьдчилан цэвэрлэх байгууламж угсрах, суурилуулах ажлын явц, хэвийн ажиллагаанд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авах арга хэмжээний зөвлөмж боловсруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтын удирдамжийг Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/65 дугаар тушаалаар баталсан. Уг удирдамжийн хүрээнд дээрх хяналт шалгалтын холбогдох байгууллагуудтай хамтран 14-21 хоногийн дотор гүйцэтгэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 50% |
| | | | УБЗАА, НХШГ,НБОГ | - | 2023 | 10 | Нэгж байгуулах ажлын явц | хувь | 100 | - | | | |
| | | | НХШГ, НБОГ, НХХААГ, НЭМГ,НХХГ, УСУГ ОНӨААТҮГ | - | 2023 | - | Хяналт шалгалт, зөвлөх ажлын явц | хувь | 100 | - | | | |
| 5.3 Ил тод байдал, хяналт | | | | | | | | | | | | | |
| Салбарын үр дүн: Нийслэл дэх төрийн хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж, хяналт шалгалтын ажлын үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ. | | | | | | | | | | | | | |
| 367 | НХТЖҮЧ-5.1, 5.2 | Улсын /ахлах/ байцаагчдыг мэргэшүүлэх багц сургалтын хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх | НХШГ | НТ | 2023 | - | Хөтөлбөрийн хэрэгжилт | Хувь | 100 | 100 | 0 | Нийслэлийн хэмжээнд барилга, дэд бүтцийн салбарт төрийн хяналт хэрэгжүүлж буй улсын /ахлах/ байцаагчдыг чадавхжуулах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэх, бэхжүүлэх, үр бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 42 улсын байцаагчдын мэргэшлийн судалгааг гарган, тэдгээрийн чадавхыг нэмэгдүүлэх мэргэшүүлэх багц сургалтад хамруулахаар мэргэжлийн холбоодоос санал авч "Улсын (ахлах) байцаагчдыг мэргэшүүлэх багц сургалтын хөтөлбөр" боловсруулж байна. Сургалтын хөтөлбөрийг 2025 оны 05 дугаар сарын 25-ны дотор НЗДТГ-т хүргүүлж, Хүний нөөцийн хөгжлийн хэлтэстэй хамтран зохион байгуулахаар ажиллаж байна. Мөн тус газраас улсын байцаагч нарыг мэргэшүүлэх хүрээнд дараах сургалтад хамруулав. Үүнд: 1. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын хяналтын улсын (ахлах) байцаагчдыг чадавхжуулах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, мэргэшүүлэх, тулгамдаж байгаа асуудлаар санал солилцох, туршлага судлах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор "Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын аймаг, нийслэлийн улсын (ахлах) байцаагчдыг чадавхжуулах, туршлага солилцох сургалт"-ыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Салбарын хяналтын газар, нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс хамтран 2025 оны 02 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд зохион байгуулсан. 2. ГОУХАН/GIZ-ийн хэрэгжүүлж буй "Улаанбаатар хотын орон сууцны эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх" (RePaRe) төслөөс төрийн байгууллагуудын барилгын эрчим хүчний хэмнэлт, үр ашгийн чадавхыг бэхжүүлэх хүрээнд зохион байгуулсан "Барилгын эрчим хүчний үр ашиг" сэдэвт сургалтад 2025 оны 03 дугаар сарын 15,16, 22, 23-ны өдрүүдэд нийт 26 албан хаагч хамрагдсан. 3. Нийслэлийн Прокурын газраас 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан "Зөрчлийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал" сэдэвт сургалтад тус газрын 30 албан хаагч хамрагдсан. | 50% |

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА Б.ОЮУНТУЯА

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Б.БАЙГАЛМАА

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ, ТАЙЛАН ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН М.ГАЧМАА